

БАЯН-ӨНДӨР СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН  
ХОРООНЫ 2020-2024 ОНЫ МӨРИЙН ХӨТӨЛБӨР

2020 оны 06 сарын 24

Булган

**НЭГ. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО**

**1.1 Орлоготой иргэн**

1.1.1 Орлоготой иргэн зорилтын хүрээнд сумын хэмжээнд Иргэддээ ажил мэргэжлийн чиг баримжаа олгох төрөлжсөн богино хугацааны сургалтуудыг хамтрагч байгууллагуудтай хамтран зохион байгуулах

1.1.2 Сумандаа жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжиж хуучин соёлын төвийн барилгыг засварлаж бизнес хөгжлийн төв болгоно

1.1.3 “Хуримтлалтай хонгорчууд” хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлж “Хүүхэд бүрийг хадгаламжтай болгох “Хуримтлалтай хүүхэд” хөтөлбөр хэрэгжилтийг хангаж ажиллана

1.1.4 Сумын төвийн орон сууцны хангамжийг нэмэгдүүлж инженерийн нэгдсэн шугам сүлжээтэй орон сууцны тоог нэмэгдүүлнэ.

**1.2 Эрүүл иргэн**

1.2.1 Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, эрүүл амьдралын зөв дадлыг төлөвшүүлэх чиглэлээр сургалт сурталчилгааг тогтмол зохион байгуулна

1.2.2 Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоог багийн түвшинд давтамжтайгаар хэрэгжүүлж, сумын эрүүл мэндийн төвийн шүдний эмчийн орон тоог батлуулж, тоног төхөөрөмжөөр ханган, хүн амын дундах шүдний өвчлөлийг бууруулах

1.2.3 “Элэг бүтэн Баянхонгор” хөтөлбөрийг үргэлжлүүлж, “Хавдрын эсрэг хамтдаа” хөтөлбөрийг хэрэгжилтийг хангаж ажиллана

1.2.4 Суманд шинэ эрүүл мэндийн төв барьж, нөхөн сэргэх физик эмчилгээний тоног төхөөрөмжөөр хангаж, иргэдэд үйлчлэх хүртээмжийг нэмэгдүүлнэ.

1.2.5 Сумын төвийн хүн амыг цэвэр ундны усаар хангах асуудлыг шийдвэрлэх

**1.3 Чанартай боловсрол**

1.3.1 Суманд 240 хүүхдийн сургууль мөн цэцэрлэг шинээр барина.

1.3.2 Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын орчны стандартыг хэрэгжүүлж, сургуулийн байгалийн ухааны төрөлжсөн кабинетуудыг шаардлагатай сургалтын хэрэглэгдэхүүнээр, бага ангийн хүүхдүүдэд юмс, үзэгдлүүдийг бодитоор тайлбарлан таниулах лабораториуд байгуулж, хүүхдийн техник сэтгэлгээ, оюун ухааныг хөгжүүлэх “Өсвөрийн зохион бүтээгч” клубийг сургууль дээр байгуулж ажиллуулна.

1.3.3 Оюутны сургалтын тэтгэлэгт хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлж, сурагч, оюутнуудын хөгжих, төлөвших сургалтуудын зохион байгуулна.

*М.ЖАРГАЛСАЙХАН*  
*М.ЖАРГАЛСАЙХАН*  
*М.ЖАРГАЛСАЙХАН*  
641714  
БЮА0067  
000000001

1.3.4 Зорилтот бүлэгт чиглэсэн нийгмийн халамжийн үйлчилгээний чанарыг сайжруулах, өрхийн амьжиргааг нэмэгдүүлэх бодлого боловсруулан хэрэгжүүлнэ.

1.3.5 Гэр бүлд зөвлөгөө өгөх үйлчилгээг боловсронгуй болгож, гэр бүл төлөвлөлтийг сайжруулсан бодлого боловсруулж, хэрэгжүүлнэ

1.3.6 Хүүхэд, багачуудын бие даах чадварыг нэмэгдүүлж, хөгжүүлж, тэдний төлөвшлийг сайжруулах чиглэлээр шат дараатай арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Сумын хүүхдийн зөвлөл, хамтарсан багийн үйл ажиллагааг сайжруулж, гэр бүл, хүүхэд хамгааллын асуудлыг бодлогын төвд байлгана.

1.3.7 Залуучуудын хөгжил төлөвшлийг сайжруулж, нийгмийн оролцоог нэмэгдүүлж, идэвхтэй амьдралыг нь дэмжсэн бодлого боловсруулж, Залуучуудын хөгжлийг дэмжих бодлогыг хэрэгжүүлж залуучуудын амралт чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх “Залуус хөгжлийн төв”-ийг байгуулна.

1.3.8 “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах, нийгмийн хамгаалал, хөгжлийг сайжруулах” хөтөлбөр хэрэгжүүлнэ.

1.3.9 Ахмад настнуудын ажил амьдралын баялаг туршлагыг бусдад өвлүүлэн сургах, тэднийг халамжлах, сэтгэл хангалуун өөдрөг байлгах зорилго бүхий “Ахмадын өргөөг”-ийг сайжруулан, хамтран ажиллана.

1.3.10 Соёл урлагийн байгууллагын үйл ажиллагааг хөдөөд чиглүүлж, шаардлагатай тоног төхөөрөмж хувцас хэрэглэлээр хангаж, хоёр жилд 1 удаа соёл урлагийн өдрүүдийг суманд зохион байгуулж ардын авьяастнуудыг нийтэд сурталчилж, алдаршуулна

1.3.11 Соёлын ордон шинээр барьж, сумын музей дэх хосгүй үнэт үзмэрүүдийг сурталчлан таниулж, үзмэрийн тоог нэмэгдүүлж, Соёлын өвийг хадгалан хамгаалж, өвлүүлэн, баяжуулан хөгжүүлж буй соёлын биет бус өв тээгч нарыг урамшуулах тогтолцоог бүрдүүлнэ.

## ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

### 2.1 Үйлдвэржилтийн бодлого

2.1.1 “Тунгалаг санхүү” хөтөлбөр, “Хуримтлалтай хонгорчууд” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

2.1.2 Мал нядлах, савлах бага оврын үйлдвэр байгуулж, малчдын орлогыг нэмэгдүүлнэ.

2.1.3 Барилгын материал үйлдвэрлэх, арьс шир боловсруулах үйлдвэр байгуулна.

2.1.4 Сумд аяллын маршрут, брэнд бүтээгдэхүүн үйлчилгээтэй болж аймгийн аялал жуулчлалын нэгдсэн сүлжээнд холбогдох, “Хот айл-жуулчны бааз” төсөл хэрэгжүүлж малчин өрхүүд жуулчин хүлээн авч, өрхийн орлогоо нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлнэ

2.1.5 Сумын төвийг 380/04кВ-ын шугамын шинэчлэлийг хэрэгцээ, шаардлагын дагуу нэмэгдүүлж, гудамж талбайн гэрэлтүүлэг, тохижилтыг хийж гүйцэтгэнэ.

2.1.6 Алслагдсан багт үүрэн сүлжээний хамрах хүрээг өргөтгөнө.

2.1.7 Нэгдсэн халаалтын системийг өргөтгөж айл өрхүүдийг холбоно

2.1.8 Сургууль, цэцэрлэг, дотуур байрны ариун цэврийн байгууламжийн асуудлыг шийдвэрлэх

2.1.9 Суманд нисэх онгоц хөөрөх буух зурвас байгуулж, тогтмол нислэгтэй болно

  
  
  
 3544  
 3007423  
 000000002



2.1.10 Говийн бүсийн сумдад хатуу хужилттай зам тавих зураг төсөв боловсруулж, сумын төвд хатуу хучилттай зам тавьж, хөдөөгийн зарим зам гуу, жалгуудыг үе шаттайгаар засварлана.

### ГУРАВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

- 3.1 Төрийн байгууллага бүрд төрийн албан хаагчийн "Нийгмийн баталгааг хангах" хөтөлбөр, төрийн албан хаагчийн "Сургалтын хөтөлбөр"ийг батлуулан хэрэгжүүлж, "Орон сууц хашаа байшин худалдан авахад санхүүгийн дэмжлэг үзүүлэх" журмыг хэрэгжүүлэх ажлыг жил бүр зохион байгуулах
- 3.2 Төрийн албаны шийдвэр гаргах үйл явцад иргэд саналаа өгөх, хяналт тавих боломж бүхий цахим системийг нэвтрүүлэх
- 3.3 Төрийн үйлчилгээг операторын үйлчилгээнд шилжүүлж, үйл ажиллагааг нь чанаржуулж тогтмолжуулна
- 3.4 Төрийн байгууллагуудын дотоод дэг журам, алба хаагчдын ажлын уялдаа холбоог сайжруулж, ажлын чанар, хариуцлагыг нэмэгдүүлнэ.
- 3.5 Хил хамгаалалтад туслах хүчний зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлнэ

### ДӨРӨВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

- 4.1 Улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газрын хэмжээг нэмэгдүүлж, нэн ховордсон ургамлыг тарималжуулах ажлыг хэрэгжүүлэх
- 4.2 Зэрлэг ан амьтанд зориулсан автомат гүн өрмийн худаг гаргах, хоол тэжээлийн био техникийн арга хэмжээг тогтмол авна
- 4.3 Сумын төвд Мод үржүүлгийн газар байгуулж, сумын төвийн тохижилтын хүрээнд айл өрх, албан байгууллага бүх нийтийн эзэмшил газруудыг тохижуулах, зүлэгжүүлэх, мод тарих ажлыг бүх нийтийн ажил болгон хэрэгжүүлнэ.

### ТАВ. ХҮНС ХӨДӨӨ АЖ АХУЙ

- 5.1 Хөдөө аж ахуйн салбарт малчид, тариаланчдын залгамж халааг бэлтгэх "Илгээлтийн эзэн-III" аяныг хэрэгжүүлнэ
- 5.2 "Монгол мал-2" хөтөлбөрийг хэрэгжүүлж, мал угаалгын ванны тоог нэмэгдүүлж, малыг эрүүлжүүлэх, чанар, ашиг шимийг сайжруулах ажлыг эрчимжүүлж, малын тоог чанарт шилжүүлж ашиг шим, хүртээмжийг сайжруулах, Идрэнгийн цагаан ямааны судалгааны ажлыг нэмэгдүүлж, мэдээллийн санд бүртгэлжүүлэх, ээмэгжүүлэх ажлыг үргэлжлүүлж, сумын мал сүргийн чанарыг сайжруулах зорилгоор шилмэл омог, үүлдрийн хээлтүүлэгч малаар хангах ажлыг дэмжинэ.
- 5.3 Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлж, жил бүр гүн өрмийн худаг гаргаж, гар худаг гаргасан иргэдийг урамшуулна
- 5.6 Газар тариалангийн тоног төхөөрөмжөөр хангаж, газар тариалангийн тариалалтын хэмжээг нэмэгдүүлж, малын тэжээлийн ургамал тариалах нөхцөл боломжоор ханган, олон улсын төсөл хөтөлбөрийн байгууллагаар дамжуулан хүлэмжийн тариалан эрхлэх сонирхолтой иргэдийг дэмжинэ

МЭДЭЭЛЛИЙГ БИЧСЭН  
БАЯН-ӨНДӨР МОНГОЛАРДЫН НАМЫГ ТӨЛӨӨЛЖ  
ДЭД ДАРГА У.БАЛЖИННЯМ

